

<https://doi.org/10.69561/mjac.v25i49.3842>

Article | Fasc.17

## Өндөр гэгээн Г.Занабазарын өв, “МОНГОЛ ХЭВ МАЯГ”-ийн тухай асуудалд

Нарандоржийн Оргилболд 

Шинжлэх ухаан технологийн их сургууль, Үйлдвэрлэлийн технологийн сургууль,  
Дизайны тэнхим, Улаанбаатар, Монгол Улс  
✉ orgilbold\_n@must.edu.mn

**Хураангуй.** Орчин цагийн өрнө, дорнын урлаг судлалд Занабазарын ур хийцийг “Хятад-Төвөдийн хэв маягийн нэгэн дэг сургууль” гэж үзэж байна. Хэдийгээр монголын болон зарим гадаадын судлаачид монгол шүтээн урлалын уламжлалыг Г.Занабазараас угшилтай *буддын урлагийн монгол дэг сургууль* хэмээн томъёолсон байдаг ч хэв маягийн харьцуулсан дүн шинжилгээ хийгдээгүй. Судалгааны ажлын хүрээнд Ням-Осорын Цүлтэм, Эвелина Ганевская, Сүрүн-Ханда Сыртыпова нарыг сонгон авч Өндөр гэгээний ур хийцийн хэв шинжид хийсэн тэдний үнэлэлт, дүгнэлтийг задалж, харьцуулсан дүн шинжилгээг хийж, хэв маягийн структуралист загварлалд оруулж тусгалаа. Ингэснээр Өндөр гэгээн Занабазарын хэв маяг, буддын урлагийн монгол хэв маягийг оновчтой тодорхойлоход ач холбогдолтой юм.

Мөн тус өгүүлэлд “монгол хэв маягийн” тухай асуудлыг эртний эх сурвалжуудыг судалж тогтоох боломж буй тухай таамаглалыг дэвшүүлсэн болно.

**Түлхүүр үгс:** Өндөр гэгээн Занабазарын ур хийц, монгол хэв маяг, монголын буддын урлаг

## The problem of Zanabazar’s heritage as the basis of the Mongolian style

Orgilbold Narandorj 

Department of Design, School of industrial Technology, Mongolian University of  
Science and Technology, Ulaanbaatar, Mongolia  
✉ orgilbold\_n@must.edu.mn

**Abstract:** According to the bibliographies of contemporary Western and Eastern art studies, Zanabazar’s artwork is categorized as “a school of the Sino-Tibetan style”. A comparative analysis of the style has not been conducted, even though Mongolian and some foreign experts have defined the Mongolian iconography art tradition as a Mongolian school of Buddhist art originating from G. Zanabazar. Nyam-Osoryn Tsultem, Evelina Ganevskaya, and Surun-Khanda Syrtypova were selected for the study; their evaluations and conclusions regarding the aesthetics of Undur Gegen’s artwork were examined, contrasted, and reflected in the structuralist model of the style. This is vital

for the logical assessment of the Buddhist art of Mongolia and the style of Undur Gegen Zanabazar.

The paper also suggests that the “Mongol style” issue may be identified by examining ancient sources.

**Keywords:** *Style of Zanabazar, “Mongolian Style”, Mongolian Buddhist Art*

## Оршил

Монголын их соён гийгүүлэгч, буддын урлахуйн ухааны сод төлөөлөгч Өндөр гэгээн Г.Занабазар хүн төрөлхтөнд буддын урлагийн гайхамшигт өвийг үлдээсэн суутан. Өндөр гэгээний ур хийцийн хэв шинжийн судалгааг 1982 онд анх монголын урлаг судлаач Ням-Осорын Цүлтэм эхлүүлсэн бол, анхны өрнөдийн судлаач нь Эвелина Ганевская юм. Сүүлд урлаг судлаач Сүрүн-Ханда Сыртыпова хэв шинжийн тухай дорвитой ажлыг хийж хэвлүүлжээ. Өндөр гэгээний өв, дэг сургуулийг олон улсад *төвөдийн хэв маягийн нэгэн дэг сургууль* хэмээн ангилж буй тухай Сүрүн-Ханда Сыртыпова “Занабазарын код” номдоо бичжээ (Сыртыпова 2023, 98). Энд өрнөдийн судлаачид хятад нөлөөлөл, ижилслийг тодотгосон *хятад-төвөдийн хэв маяг*<sup>1</sup> хэмээн бичиж заншсан болохыг онцлох нь зүйтэй.

Тус судалгааны зорилго нь Г.Занабазарын ур хийцийн хэв шинжийг тодорхойлсон судлаачдын үнэлэлт дүгнэлтийг нэгтгэн харьцуулж, “монгол хэв маяг”-ийг оновчтой тодорхойлох хэв шинжийн шинжлэл юм.

Судалгааны зорилгын хүрээнд дараах зорилтуудыг тавьсан болно. 1-рт, урлагийн хэв маягийн тухай онолын асуудлыг судлах; 2-рт, Өндөр гэгээний ур хийцийн хэв шинжийн тухай судалгаануудад харьцуулсан дүн шинжилгээ хийж, нийтлэг ба ялгамжтай шинжийг илрүүлэх; 3-рт, хэв маягийн шинжүүдийг ангилж, хэв маягийн онолд ойр структуралист загварчлалд оруулах юм.

Дээрх зорилго, зорилгын хүрээнд судалгааны ажилд Ням-Осорын Цүлтэм, Эвелина Ганевская, Сүрүн-Ханда Сыртыпова нарыг сонгон авч Өндөр гэгээний ур хийцийн хэв шинжид хийсэн тэдний үнэлэлт, дүгнэлтийг задалж харьцуулсан дүн шинжилгээ хийлээ. Судалгааны хүрээнд хэв маягийн онолын үүднээс Өндөр гэгээний хэв маягийн шинжүүдийг нэгтгэн таван хэв шинжид ангилан структуралист арга зүйгээр загварчилж мөн тусгалаа. Ингэснээр Г.Занабазарын хэв маяг, ангилал зүйн хүрээнд нэгтгэгдэж, цаашлаад буддын урлагийн монгол хэв маягийг оновчтой тодорхойлоход чухал үүрэгтэй.

### Судалгааны арга зүй

Судалгааны ажлын хүрээнд харьцуулсан дүн шинжилгээ, ангилал зүй, индукц, дедукц, структуралист арга, арга зүйг ашигласан болно.

### Судалгааны үр дүн

Судалгааны үр дүнд судлаачдын тодорхойлсон Г.Занабазарын урлагийн үндсэн хэв шинжүүдийг тодруулахын сацуу зарим дүгнэлтийг хийх боломжтой болж байна. Тухайлбал, Н.Цүлтэм анх Г.Занабазарын хэв маягийг тодорхойлсон үнэлэлт

<sup>1</sup> Sino-Tibetan Style

дүгнэлтийг хийж, судлаачид (Э.Ганевская, С.Д.Сыртыпова, Ц.Уранчимэг) түүн дээр тулгуурлан өргөжүүлэн баяжуулсан, тус судалгаа нь формал стилистикийн арга зүйн хүрээнд түлхүү хийгдэж, их мастерын бүтээлдээ ашигласан хээ угалз, чимэглэл, соёлын агуулгын хүрээнд хийгдэж хөгжиж ирсэн байна. Хэв маягийн онолын үүднээс авч үзвэл, судлаачдын түгээмэл ашигласан формал стилистикийн дүн шинжилгээнээс гадна өөр бусад урлаг судлалын болон салбар хоорондын судалгааг өргөжүүлэх нь зүйтэй билээ. Түүнчлэн, эртний судар бичгүүдийг судалж, эх сурвалжийн арга зүйгээр “монгол хэв маяг”-ийг тодорхойлох боломж буйг тус өгүүлэлд тусгав.

**Хэв маягийн онолын тухай асуудал:** Юуны өмнө “хэв маяг”-ийн тухай асуудал нь эртний грек сэтгэгчдээс эхлэн өнөөг хүртэл судлаач, сэтгэгчдийн хэлэлцсээр, зөвшилцсөөр буй сэдэв болохыг онцлох нь зүйтэй болов уу. Хэв тухай асуудал нь “гадаад хүчин зүйл, үйлдэлд үзүүлж буй ухамсрын тусгал буюу гоо зүйн уг чанарт хамаарах” бөгөөд үнэлэмжийн чанартай байдгаараа онцлог. Ийнхүү хэв маягийн тухай асуудал нь аксиологид тулгуурласан объект ба субъектийн харилцан хамааралд оршдог сэдэв билээ. Хэдийгээр “хэв маяг” нь ээдрээтэй феномен боловч түүний мөн чанар нь илэрхий байдаг нь маргаангүй юм.

Урлагийн онолын хүрээнд “хэв маяг” гэх ойлголтын нэгдсэн тодорхойлолт үгүй. Тухайлбал, Генрих Вельфлин “цаг хугацааны хэмлэл эсвэл үндэстэнд илрэх хэв шинжийн ижилсэл” гэх салаа утгатай тодорхойлолтыг өгөөд “хэв маягийн хоёр үндэс” (Вельфлин 2004) хэмээн тодотгон бичсэн байдаг бол Майер Шапиро “нэг ба олон уран бүтээлчдийн туурвилд илэрч буй өөрчлөгдөшгүй хэсэг, шинж чанар, илэрхийлэл зэрэг багтсан тогтвортой хэлбэр” (Schapiro 1953, 287), Эрнст Гомбрих “уран бүтээлд зүй тогтол илэрч буй онцлог арга” (Gombrich 1998) зэргээр тодорхойлохыг оролдож ирсэн.

Дүрслэх урлагт эгэл хэлбэрээс (форм), хэв шинжит хэлбэрт (стилем) шилжсэн нь XIX-XX зууны зааг гэж үздэг. Энэ үеэс агуулга хэлбэрийн харилцан хамаарал, түүхэн нөлөөллийн санаанууд шинжлэх ухаанч байдлаар боловсруулагдаж иржээ. Тухайлбал, хэлбэр зүй ба билэг агуулгад дулдуйдсан урлаг судлал (Вельфлин, Дворжак), хэлбэрт агуулгын хэв шинжит өргө зүйн үзэл баримтлал (Гильдебранд), хэв маягийн ойлголтын түүхэн шинж (Гете, Кассирер, Лосев) зэргийг дурдаж болно.

Хэв маягийг тодорхойлоход түүх, философи, соёл судлал, семиологи, гоо зүйн хүчин зүйлүүдийг харгалзан хэв маяг тогтоох оролдлогыг урлаг судлалд өнөө хэр хийсээр байна. Дээрх хүчин зүйлүүдээс гадна урлагийн судлалын гэх онцлог болох урлагийн тиг (иконографи), стилистик (хэв шинжийн), сэдэв, бүтцийн бүдүүвчлэл, зохиомжийн арга, төрөл зүйл, материал, техник зэрэг олон шинж бий.

Хэв маягийн “ойлголт”-ын хүрээнд илэрсэн тодорхойлолтуудаас дараах хоёрыг оновчтой хэмээн онцолж байна. Оросын суут эрдэмтэн, онолч А.Ф.Лосев олон судалгаа, тодорхойлолтуудад дүн шинжилгээ хийсний үр дүнд бий болсон “хэв маяг бол бүтэц юм” (Лосев 1994, 216) гэх товч атлаа оновчтой тодорхойлолтыг оноосон байдаг. Мөн оросын эрдэмтэн В.В.Бычковын “...түүхийн эрин цаг үед урлагт тогтвортой оршиж байсан тодорхой чиглэл, урсгал, дэг сургууль ба нэг уран бүтээлчийн өөрийн гэх онцлогтой өвөрмөц тигийн загварчлал, ...уран сайхны сэтгэлгээ, дүрслэлийн уран сайхны илэрхийллийн аргууд, бүтээц ба хэлбэр зүйн

*бүтэц*, ...тодорхой цаг үеийн оюун санааны билгийг (нийтийн уран сайхны үл ухамсарлахуй, дүрсэлбэрийн анхдагч дүр, эртний хэлбэр) илэрхийлэхүйц *уран сайхны цогц хэлбэр зүйн чиг хандлага*, ...өөрийн цаг үеийн санааг мэдрэх оюун санааны өндөрлөгт хүрсэн бүтээлч хүн, дүрслэн хэлбээс *эрин цагийн гоо сайхны “бэлгэдэл”*, ...үгээр тодорхойлогдошгүй зарчим, идеал санаа, бүтээлч долгилолтоор баялаг оюун санааны *чинадад аялах дүрслэлийн гоо зүйн загвар*, ... чухамдаа ийм цог заль үгүй бол хэв маяг замхардаг. Гагцхүү маяг донж, аргын тогтолцоо мэт гадаад ул мөр үлддэг” (Бычков 2002, 281-284) гэх дэлгэрэнгүй тодорхойлолт юм.

**Өндөр гэгээний ур хийц, монгол хэв шинжийн тухай судалгаанд хийсэн харьцуулсан дүн шинжилгээ:** Өндөр гэгээний туурвил зүйн тухай Н.Цүлтэм (“Занабазар”, 1982), Д.Дашбалдан, Л.Батчулуун, Ц.Уранчимэг (“Монголын Их Хүрээ хийдийн буддын шашны урлаг”, 2016), С.Д.Сыртыпова, бурхан бүтээх тигийн хүрээнд бурханч лам Г.Пүрэвбат (“Монголын уламжлалт урлахуйн ухааны цуврал 10 боть”), Занабазарын архитектурын өвийн тухай монголын судлаач Д.Майдар (“Монголын их барилга”, 1972; “Монголын архитектур ба хот байгуулалт”, 1972), ЗХУ-ын архитектор судлаач Н.М.Щепетильников (“Архитектура Монголии”, 1960), буддын урлаг, түүн дотроо уран баримлын дэг уламжлалын хүрээнд В.В.Деменова, Ю.И.Елихина, соёлын контекстийн хүрээнд М.Ю.Шишин, харин урлагийн онол, загвар хийц, хэв маягийн шинжийн судалгааг Н.Цүлтэм, Ц.Уранчимэг, Э.В.Ганевская, С.Д.Сыртыпова нар хийсэн байдаг байна.

Судалгааны хүрээнд Өндөр гэгээний ур хийц, монгол хэв шинжийн харьцуулсан дүн шинжилгээг Н.Цүлтэм, Э.В.Ганевская, С.Д.Сыртыпова нарын бүтээлүүдэд туссан үнэлэлт дүгнэлт, бүтээлийн утга тайлалд тулгуурлан хийх болно.

Ардын зураач, Төрийн соёрхолт, Урлагийн гавьяат зүтгэлтэн, урлаг судлаач Ням-Осорын Цүлтэм анх удаа монголын урлаг хийгээд Өндөр гэгээний бүтээлүүдэд дүн шинжилгээ хийж, үр дүнгээ урлагийн онолын түвшинд бичиж шинжлэх ухаанд нэвтрүүлсэн билээ. Тэрээр “Монголын эртний урлаг XX зууны эхэн үе” (1982), “Уран барималч Г.Занабазар” (1982), “Монгол уран баримал” (1989) зэрэг бүтээлдээ Өндөр гэгээний урлагийн уран сайхны болон гоо зүйн үнэ цэнийг өгүүлсэн юм.

Түүний 1984 онд Москва хотноо хэвлүүлсэн “Искусство Монголии с древнейших времен до начала XX века” буюу “Монголын урлаг нэн эртнээс XX зууны эхэн үе хүртэл” (1984) бүтээлд Г.Занабазарын ур хийцийн хэв шинжийн тухай Очирдара бурхан, Цагаан болон Ногоон дарь эх бүтээлүүдэд формал-стилистикийн тайлал бичих замаар хэв шинжийг тодорхойлсон байдаг. Н.Цүлтэм тус бүтээлдээ Занабазар болон түүний ур хийцийн залгамжийн тухай “Монголын дундад зууны урлагийг хүн төрөлхтний гоо зүйн үнэлэмжийн түвшинд хүргэж чадсан анхны аугаа уран бүтээлч бол Занабазар билээ. Харамсалтай нь Занабазарын шавь нар нь түүний бүтээлийг даган дуурайхаас илүүг бүтээсэнгүй. Ийнхүү тэрээр урлахуйн ухааны оргилд хүрсэн дахин давтагдашгүй мастер хэвээр үлдсэн юм” (Цүлтэм 1984, 85) хэмээн дүгнэжээ. Мөн тэрээр монголын шүтээн урлал хятадын сүүл үеийн уран бүтээлчдэд нөлөөлж байсныг дурдаж бичжээ.

Занабазарын уран баримлын онцлогийг тодорхойлох оролдлогыг хийсэн анхны европ судлаачдын нэг бол Э.В.Ганевская (Сыртыпова 2023, 147) хэмээн

С.Д.Сыртыпова онцолжээ. Үүнийг анхны өрнийн урлаг судлаачдын нэг гэвээс зохилтой юм. Эвелина Владимировна Ганевская нь монголын урлаг, түүн дотроо Г.Занабазарын бүтээлүүдэд дорвитой судалгааг хийсэн байдаг. Тэрээр Дорнын урлагийн музейн сан хөмрөгт хадгалагддаг 19 хүрэл баримлыг монгол мастеруудын бүтээл болохыг тодорхойлж, хэв маягийн шинжээр нь Занабазар ба бусад хэмээн хоёр хуваасан байдаг. “Тэрээр зүй ёсоор Занабазарыг хятад ба төвөдийн уламжлалаас ангид монголын шашны урлагт үндэсний гэх хэв шинжийг бүтээгч бөгөөд буддын урлагийн монгол үзэл баримтлал түүний Язгуурын таван бурхан, Цагаан дарь эхэд илэрсэн байдаг хэмээн онцлон тэмдэглэж байв” хэмээн С.Д.Сыртыпова дүгнэн бичсэн байдаг.

Э.В.Ганевская “Буддын таван аймаг. Дорнын урлагийн музейн сан хөмрөгт хадгалагдаж буй IX-XIX зууны умардын буддын цутгуурын баримал” номын “XVII-XIX зууны монголын уран баримал” бүлэгт Монгол дахь буддын урлагийг XIII зуунаас, Хубилай хаантай холбон авч үзсэн байдаг ба Г.Занабазараас угшилтай шүтээн урлалын уламжлалыг *буддын урлагийн монгол дэг сургууль* хэмээн томъёолсон байдаг. Мөн Занабазарын урлагт илэрдэг монголчуудын язгуур уран сайхны мэдлэг, гоо зүй нь их мастер угшил үндэстэйгээ хүйн холбоотойг илэрхийлнэ хэмээн онцолсон байдаг. Дээрх дүгнэлтүүдийг монголын судлаачид ярьж бичсээр иржээ.

Харин “Буддын таван аймаг. Дорнын урлагийн музейн сан хөмрөгт хадгалагдаж буй IX-XIX зууны умардын буддын төмөрлөг уран баримал” бүтээлдээ буддын урлагийн цутгуур урлалын мэргэжилтэн Александр Дубровин, Эвелина Ганевская нарын Монгол, Хятад, Төвөд, Балба, Энэтхэг орнуудын буддын урлагийг харьцуулсан, дүрслэн тайлбарласан бичвэрүүдээс дараах байр суурийг онцолж байна.

1. Умардын буддын шашинт орнууд хоорондоо түүх, соёл, эдийн засаг ба шашин шүтлэгийн холбоо их гүн гүнзгий бөгөөд эртнийх юм. Тиймээс ижил төстэй чанар их бий (Э.Ганевская);
2. Монголын шашны уран баримал бусад орны бүтээлүүдээс ялгарах ялгамж бага. Ялангуяа Хятад, Төвөдийн баримлуудтай хэв маягийн хувьд их төстэй. Энэ нь Монгол тус орнуудтай ойр харилцаатай байсантай холбоотой (А.Дубровин);
3. Цутгуурын технологийн хувьд мөн л онцлог бага XVIII зуун хүртэл төвөдийн нөлөө хүчтэй байх үед гурван элемент бүхий найрлагатай гуулийг түгээмэл ашигладаг байсан бол сүүлд хятадын нөлөөгөөр дөрвөн элемент бүхий найрлагатай гуулийг шүтээн урлалдаа ашиглах болсон. Мөн Монголд шүтээн урлал хожуу дэлгэрсэн (А.Дубровин);

А.Дубровин, Э.Ганевская нар өөр хоорондоо харилцан адилгүй дүгнэлтийг өгсөн байдаг. Хэрэв А.Дубровин хэв шинжийн хувьд ялгамж бага гэж дүгнэсэн бол Э.Ганевская ялгамжийг Занабазарын ур хийц дээр тулгуурлан урлаг судлаачийн хувьд тодорхой хэв маягийн дүгнэлт хийсэн байдаг. Дээрх үзэл баримтлалын үүднээс авч үзвээс, монголын буддын урлаг хэлбэр зүй, хэв шинжийн хувьд ижил түвшинд хөгжиж, төлөвшсөн хэмээн дүгнэх боломжгүй юм.

Занабазарын ур хийц умардын буддын шашинт орнуудын урлахуйн ухаанд ихээхэн нөлөөлсөн байдаг. Хэдийгээр монголын шүтээн урлалд хятад, төвөдийн

нөлөөг гаднын судлаачид онцолдог боловч Занабазарын ур хийц тухайн улсуудад нөлөөлж байсан бөгөөд даган дуурайх оролдлогууд түгээмэл байсныг дурдах хэрэгтэй.

Энэ тухай монгол судлаач Юлия Игоревна Елихина Эрмитажийн музейд (ОХУ) хадгалагдаж буй Занабазар болон түүний дэг сургуулийн сан хөмрөгийн тухай өгүүлсэн судалгааны ажилдаа дипломатч, судлаач Э.Э.Ухтомскийн цуглуулгын хятад дархны урласан Аюуш бурхан (*зураг 1*) болон гарвал тодорхойгүй нэрт угсаатан зүйч, судлаач П.К.Козловын цуглуулгын Амиитаба бурхныг (*зураг 2*) онцолжээ. Дээрх бурхдын хийцлэлд Занабазарын дэг сургуулийн стилистикийн онцлог шинж болсон анатомийн зарим шинжүүд, бадамлянхуа сэнтийн хийцлэл, нарийн хийцлэлтэй товгор чимэглэлүүд, хээ угалзыг дуурайх гэсэн оролдлогуудыг хийсэн байна. Дээрх урлаачид Занабазарын дэг сургуулийн уламжлалыг сайн мэддэг байсан нь илэрхий (Elikhina 2020, 675-676).

Э.Ганевская хожуу үеийн монголын шүтээн урлалын тухай Н.Цүлтэмийн байр суурийг бататган: "...Энэ нь умардын буддын сүүл үеийн уран баримлын нийтлэг шинж бөгөөд хятадын урлангуудын их хэмжээний бүтээгдэхүүний шахалт дор ялгаа арилан балартах нь янз бүрийн орнуудад түгсэн юм. Иймээс хэт адилхан шинжтэй сүүл үеийн бүтээлүүдийг атрибуцчлах нь нэн ээдрээтэй асуудал болсон билээ" (Ганевская 2004, 81) хэмээн бичсэн байдаг бөгөөд үүнээс монголчууд бид XVIII-XIX зуунд Занабазарын дэг сургуулийн уламжлалыг "гээсэн" хэмээн дүгнэж болох юм.

Өндөр гэгээн Г.Занабазарын өв, уран бүтээлийг урлагийн онолын хүрээнд тууштай судалж байгаа судлаачдын нэг бол ОХУ-ын ШУА-ийн Дорно судлалын хүрээлэнгийн тэргүүлэх эрдэм шинжилгээний ажилтан монгол, төвөд судлаач Сүрүн-Ханда Дашинимаевна Сыртыпова юм. Тэрээр өөрийн 2019 онд монгол англи хэлээр Улаанбаатар хотноо хэвлүүлсэн "Өндөр гэгээн Занабазарын загвар хийц" номоо шинэчлэн сайжруулж, засварлан нэмж 2023 онд орос хэлнээ "Занабазарын код" нэртэйгээр хэвлүүлсэн. Дээрх бүтээлүүддээ тэрээр Занабазарын бүтээлийн онцлогийг гурван хэсэгт ангилан тусгасан байдаг (Сыртыпова 2019). Мөн Сүрүн-Ханда Сыртыпова өөрийн судалгааны ажлын бүтээлдээ хэв маягийн шинжүүдийг дурдаад өнгөрөлгүй судалгааны ажил явуулж дэлгэрэнгүй задалж, эшлэн тайлбарласан байдаг.

Бидний судалгааны ажлын хүрээнд авч үзэж буй гурван судлаачийн үнэлэлт, дүгнэлтийг дараах байдлаар ангилан, харьцуулалт хийлээ.

*Хүснэгт 1. Н. Цүлтэм, Э.Ганевская, С.Д.Сыртыпова нарын  
дүн шинжилгээг харьцуулсан байдал<sup>2</sup>*

№	Н.Цүлтэм (1982)	Э. Ганевская (2004)	С.Д. Сыртыпова (2019)
<b>Урлагийн тиг буюу дүрслэхүйн эх сурвалж</b>			
1.	Занабазарын уран бүтээлүүд нь түүнийг бурхан бүтээх хувь хэмжээг нарийн тусгасан Данжуур болон энэтхэгийн эртний шастир судруудыг нэн сайн мэддэг байсныг илтгэнэ.	Занабазар бурхан бүтээх тигийг яс баримталж байсан.	Эртний энэтхэг дүрслэх урлагийн дэг жаягийн уламжлалыг чандлан хадгалсан.
2.			Бүтээлийн хэмжээний харьцааг бодит болон зөв мөрдсөн.
<b>Биеийн дүрслэлийн онцлох шинж</b>			
3.	Төгс төгөлдөр хүний өв тэгш биеийг илэрхийлэн дүрсэлсэн. Түүний бүтээлүүдийн бие төгс харьцаатай, амьд уян хатан чанартай, бие бялдар тэнхлүүн, мөр тэгш бөгөөд уян зөөлөн, бүсэлхийн уян нахилзуур, бүхэлдээ зөөлөн (бөөрөнхий) хэлбэртэй.	Буддын урлагийн эхэн үеийн бүтээлүүдэд илэрдэг “сонгодог” цэвэр хэлбэр илэрдэг.	Монгол хүний бие галбираас хуулж бурхны дүрийг бүтээхдээ өргөн мөр, гар хөлийн булчинлаг байдал, ахар хүзүү, нарийн бэлхүүс, жижгэвтэр тавхай, булцгар алга зэргийг гаргасан.
4.		Төгс биеийн харьцаатай.	
<b>Нүүр царайны онцлох шинж төрх</b>			
5.	Нүүр царай нь харьцааны зөв хувь хэмжээтэй, бодит амьдлаг шинж байдлыг шингээсэн монголжуу, хамар шулуун бөгөөд өндөр, шинэ сар шиг хөмсөгтэй, нүдний хэлбэр бадамлянхуа цэцгийн дэлбээ мэт хэлбэртэй, хацар дүүрэн, эрүү бөөрөнхий, царай орь залуу царай нь энэрэнгүй зөөлөн дүр төрхтэй, хүүхдийнх мэт цог зальтай...	Монголчуудын шинжийг шингээсэн.	Нүүр царайны хэлбэр – зөв зууван хэлбэртэй нүүр, нүүрний дүрс том, өндөр магнай, урт өндөр хамар дээрээ бараг л нийлсэн хөмсөг, яльгүй шонхор хамар, буйлс хэлбэртэй нүд, нарийн хамрын самсаа ба жижгэвтэр булцгар уруул.
<b>Гоёл чимэглэл дүрслэлийн онцлох шинж</b>			
6.	Бурхдын гоёл чимэглэл уран нарийн, тансаг хийцтэй бөгөөд монгол хээ угалзыг шингээж өгсөн.	Бурхдын чимэглэлд нь үндэсний хээ угалзыг ашигласан.	Чимэглэлийн бүтцийг сайтар задлаад ажиглавал Хүннүгийн үеийн хээ угалз ажиглагдана (энгийн цэцгэн хээ угалз, гурвалсан хээ г.м.)

<sup>2</sup> Судалгааны хүрээнд судлаачийн боловсруулсан харьцуулсан хүснэгт

7.		Бадамлянхуа цэцгийн өвөрмөц хэлбэр.	Бадамлянхуа сэнтий нь олон төрөл хийц ба баялаг чимэглэгдсэн, ургамлын аймаг урлалын сурвалж болсон.
8.		Монгол гоёл чимэглэлийг дүрсэлсэн.	Энэтхэг загварын хувцас ба гоёл чимэглэлтэй боловч монгол буюу нүүдэлчин үндэстэн ястны хээ чимэглэл ба бүтэцтэй болохыг харж болно.
9.		Чимэглэлийн деталь бүрийг нарийвчлан бүтээсэн.	
<b>Хийцлэл ба технологи</b>			
10.	Хувцасны нарийн чимхлүүр хэсэг бүр, бүхий л гоёл чимэглэл нэг хэвээр бүрэн цутгасан нь монголын цутгуурын технологийн өндөр түвшинг илтгэнэ.	Цутгалтын чанар өндөр.	Цутгалтын өндөр чанартай.
11.		Гадаргын өнгөлгөө толь мэт гялалзана.	Өөгүй өнгөлгөөтэй.
12.			Өндөр чанартай халуун хүйтэн аргаар алтадсан.
<b>Объектын субъектив шинж</b>			
13.	Бурхдын орь залуу дүр төрхөд энэрэнгүй зөөлөн шинж, энэтхэг мэргэдийг санагдуулам оюунлаг атлаа хүүхдийнх мэт цог зальтай царай, амар амгалангийн оршихуйтай, өөртөө төвлөрсөн, гүн бясалгалын дүртэй.	Амьд ертөнцөд ойр шинжтэй.	
<b>Бусад онцлох шинж (техникийн, гоо зүйн г.м)</b>			
14.	Занабазарын уран бүтээлийн хамгийн чухал ач холбогдол бол тэрээр нийтэд тогтсон хатуу тигийг даван туулж бүтээлдээ “амь бэлэглэж” чадсан явдал юм.		Баримлын бүх хэсгийн дугуйрсан байдал, хурц өнцгөөс зайлсхийх ба уян налархай шилжилт гаргасан.
15.	Занабазарын бүтээл нь санаа, дотоод агуулга, царай төрх зэрэг бүх талаараа монгол хүний гоо зүйн хүсэлд нийцэж байв.		Баримлыг бүх талаас нь сайн гүйцэтгэсэн.
16.			Дүрслэлийн цэмцгэр хийц ба шугам бүрийн төгс, уран дүрслэлийн цомхон аргачлал.

**Өндөр гэгээний хэв маягийг структуралист арга зүйгээр загварчлах нь**

Судалгааны хүрээнд хөндсөн асуудлууд болон бусад эх үүсвэрүүдэд тархсан зарим түгээмэл үзэл баримтлалын хүрээнд константуудын нэгтгэл хийж дараах байдлаар Өндөр гэгээний хэв маягийг тодорхойлох хэв шинжийг ангилж байна.



Үүнд: 1-рт, түүхэн хэв шинж; 2-рт, философи ба гоо зүйн хэв шинж; 3-рт, соёл ба нийгмийн хэв шинж; 4-рт, урлагийн онолын хэв шинж; 5-рт, тусгай ба бусад хэв шинж юм.

*Хүснэгт 2. Занабазарын хэв маягийг тодорхойлох структуралист загварчлал<sup>3</sup>*

№	Хэв шинжийн утга	Г.Занабазарын дэг сургуульд илэрдэг хэв шинж
Түүхэн хэв шинж		
1.	Тухайн цаг үеийн түүхэн нийцлийн шинж тэмдэг	1-рт, Занабазар нь монголын нийгмийг шинэ замд хөтөлсөн. 2-рт, Бүтээлүүд нийгмийн хэрэгцээ шаардлагыг илэрхийлж байсан.
2.	Хөгжлийн мөчлөгийн шинж тэмдэг	Занабазарын мутрын бүтээлүүд болон дэг сургуулийн бүтээлүүдийг онцлогийг ажиглаж, формал-стилистикийн шинжилгээнээс түүхэн мөчлөгийг гурав хуваан авч үзэж болохоор байдаг. 1-рт, <i>эхэн үед</i> тэрээр хийц, технологи, харьцааны хувьд хичээнгүй эрэл хайгуул хийж ирсэн болох нь бүтээлүүдэд илэрдэг. Тухайлбал, Занабазарын мутрын шинж илэрдэг зарим бүтээлүүд нь салангид цутгалттай, бие галбирыг хүний галбарт дөхүүлэх эрэл хайгуул хийсэн шинжтэй, материалаа ойлгохын тулд туршилтын шинжтэй цутгасан бүтээлүүд байна. 2-рт, <i>оргил үед</i> тэрээр төгс төгөлдөр гоо сайхны дүрслэхүйн хэлийг олж, төгс харьцаа, амьд нүүр царай, нарийн чимхлүүр ажиллагаатай бүрэн цутгамал бурхдыг бүтээсэн байдаг бөгөөд тэдгээр нь өдгөө монголын музейнүүдэд хадгалагдаж байна. 3-рт, <i>сүүл үе</i> нь түүний дэг сургуульд хамаарах бөгөөд хятадын массын үйлдвэрлэл, дуураймал загварууд их хэмжээгээр умард буддын орнуудад түгснээр дэг сургуулийн онцлог гээгдэж, монголчууд өөрсдөө бурхан шүтээн цөөн хийх болж хэв маягийн хувьд нийтлэг хятад хэв шинж давамгайлах болж Занабазарын дэг сургууль уналтад орсон байдаг.
Философи ба гоо зүйн хэв шинж		
3.	Түүхэн үеийн оюун санааны билгийг илэрхийлэхүйц уран сайхны цогц хэлбэр зүйн чиг хандлага	1-рт, Занабазарын бүтээл нь санаа, дотоод агуулга, царай төрх зэрэг бүх талаараа монгол хүний гоо зүйн хүсэлд нийцсэн. 2-рт, Монголд хүчтэй өрнөсөн Буддын шашны дэлгэрэлттэй холбоотой Занабазарын бүтээлүүд монголын ард түмний оюун санааны хувьд нэн чухал үүрэг гүйцэтгэж байсан.

<sup>3</sup> Судалгааны хүрээнд судлаачийн боловсруулсан хүснэгт

4.	Универсал шинж чанар	<p>1-рт, Занабазарын бүтээлүүд нь бурхан бүтээх хувь хэмжээний онол машид нарийн тусгасан байдаг нь түүний Данжуур болон энэтхэгийн эртний шастир судруудыг нэн сайн мэддэг байсныг илтгэдэг.</p> <p>2-рт, Сонгодог тигийг ягштал баримталсны үр дүнд түүний бүтээлүүдэд “сонгодог” цэвэр хэлбэр тодордог билээ.</p> <p>3-рт, Өдгөө бурхан урлаачид Занабазарын өвийг судлах болсон нь түүний бүтээлийн универсал шинжтэй холбоотой.</p> <p>4-рт, Занабазарын бүтээл нь орон нутгийн шинжтэй биш бөгөөд буддын шашинтан бүхий л үндэстэн, хувь хүнд хамаарах шинж чанартай.</p>
5.	Оригинал шинж чанар	<p>1-рт, Занабазар урьд байсан зүйлийг дуурайж гаргаагүй бөгөөд байгаль дэлхийгээсээ дуусашгүй онгод авч шинийг илэрхийлсэн.</p> <p>2-рт, Түүний бүтээлийн онцлог нь шашны хатуу хуурай тигийг эргэн харж, бурхан бүтээхдээ бүтээлчээр ашигласан байдаг. Судлаачид түүнийг тигээ хатуу чанд баримлаж ирсэн ч тигийг цоо шинээр бүтээлчээр ухамсарлаж, бүтээлдээ тусгасан гэж үздэг.</p> <p>3-рт, “Монголын их хувилгаан Г.Занабазарын бүтээсэн Дара эхийн мэлмий нь тэгш дэлгэр талибуун бөгөөд угалзтай шулуун хамрыг тод сайхан гаргасан, нүүр дүүрэн мишээл болоод төв инээмсэглэлийг уруулын доорх ялимгүй инээмсэглэлд нь уусган шингээж, үе гишүүн бүхнийг дэлгэн боловсорч буй найлзуур модон мэт орь залуугийн шинж төгс бүрдсэнээр бүтээжээ” хэмээн тэртээ XVIII зууны энэтхэг сударт бичиж тэмдэглэсэн явдал нь яахын аргагүй түүний бүтээлийн оригинал шинжийн баталгаа юм.</p>
<b>Соёл ба нийгмийн хэв шинж</b>		
6.	Эрин цагийн гоо сайхны “бэлгэдэл” болох чанар	<p>Занабазар өөрийн амьдарч байсан үеийн мөн чанарыг зөв таньж, суут хүний билиг ухаанаар өөрийн бүтээлүүддээ хүн, нийгмийн хүсэл тэмүүллийг гаргаж тавьсан бөгөөд гоо сайхныг, энэрэн нигүүлсэхүйн үзэл санааг дэлгэрүүлж байв. Түүнчлэн тэрээр буддизмыг “монголжуулах” ажлыг идэвхтэй явуулж шинэчлэлийг эрчимтэй хийж байв. Тэр нь дүрслэх урлаг, архитектур, гүн ухаан, яруу найраг, хөгжим, орчуулгын ухаан, зан заншил гээд монголчуудын амьдралын бүхий л салбарт нэвтэрсэн. Магад тиймээс буддын шашин гурав дах удаагаа Монголд дэлгэрэхдээ гүн бат байр суурийг олж авсан буй заа.</p>

7.	Нөлөөг авсан шинж	Тэрээр энэтхэг-төвөдийн хувь хэмжээний онолыг баримтлан бүтээлээ бүтээдэг байсан билээ. Харин технологийн хувьд IX-XII зуунд зүүн хойд Энэтхэгт түгэн дэлгэрсэн Пала-Сен хэв маяг, Балбын шүтээн урлалын цутгуурын технологитой төстэй. Магадгүй Занабазар бурхан урлалын энэтхэг тиг төдийгүй эртний энэтхэг технологийг ашиглаж байсан хэмээн таамаглаж болох юм.
8.	Оюун санааны нөлөөлөл	Занабазарын бүтээлээрээ дамжуулан дараах үзэл санааг түгээсэн юм. 1-рт, хүнийг хайрлахуйн үзэл санаа, 2-рт, энэрэл нигүүлслийн үзэл санаа, 3-рт, буддын шашны үзэл санааг энд онцолж байна.
9.	Орон зай, цаг хугацаа нөлөөлөл	1-рт, Занабазарын дэг сургууль монголын буддын урлагийн үлгэр жишээ болж 300 гаруй жилийн туршид оршсоор байна. 2-рт, Хятад, Төвөд, Буриад, Халимаг, өмнөд Монгол зэрэг газар нутгийн шүтээн урлалын ухаанд ихээр нөлөөлсөн. Тухайлбал, С.Б.Бардалеева Занабазарын ур хийц буриадын Оронгойн дэг сургуульд нөлөөлсөн гэж үзсэн байдаг. Эрмитажийн сан хөмрөг төдийгүй дэлхийн олон музейн сан хөмрөг, урлагийн бүтээл цуглуулагчдын цуглуулгад бид Занабазарын нөлөө дор бүтээлээ туурвисан дээрх орнуудын урлаачдын ажлыг харах боломжтой.
10.	Урлахуйн нөлөөлөл	Занабазарын ур хийцийг Монгол төдийгүй хятад, төвөд болон өмнөд монгол, буриад, тува, халимаг зэрэг буддын шашинт орнуудад даган дуурайх, сэдэл санаа авах зэрэг түгээмэл байсан. Өнөө ч бурхан урлаачид Занабазараас суралцсаар байна.
<b>Урлагийн онолын хэв шинж</b>		
11.	Урлагийн тигийн загварчлал	1-рт, бүтээлүүд нь бодит дүртэй, бурхны дүрийг хүнчлэн туурвисан. 2-рт, бурхдын нүүр царайг “амилуулсан”. 3-рт, буддын урлагийг “хөшмөл” шинжээс ангижруулсан.
12.	Бүтээц-хэлбэр зүйн бүтэцийн шинж чанар	Н.Цүлтэм, Э.Ганевская, С.Д.Сыртыпова нарын харьцуулсан судалгаанаас харна уу.
13.	Зохиомж ба зохирол	Н.Цүлтэм, Э.Ганевская, С.Д.Сыртыпова нарын харьцуулсан судалгаанаас харна уу.
14.	Стилистик шинж чанар	Н.Цүлтэм, Э.Ганевская, С.Д.Сыртыпова нарын харьцуулсан судалгаанаас харна уу.
15.	Сэдэв ба төрөл зүйл	Занабазар нь дүрслэх урлагийн бүхий л төрөл зүйлд гарамгай байсан төдийгүй утга зохиол, шашны философид ч нэвтэрхий байжээ. Мөн бурхан урлаач тул түүний бүтээлүүдийн гол сэдэв нь шашны сэдэв, бурхдын дүрслэл юм.

16.	Материал ба технологи	Ямар ч залгаасгүй хөндий цутгаж, өндөр чанартай халуун хүйтэн аргаар алтдаж, толь мэт өөгүй сайхан өнгөлгөөг хийдэг байжээ. Энэ бүхэн нь түүний онцлог талыг илэрхийлдэг. Материалын химийн найрлага нь умардын буддизмын эш бүтээлүүдтэй ижил.
17.	Арга ба техник	Н.Цүлтэм, Э.Ганевская, С.Д.Сыртыпова нарын харьцуулсан судалгаанаас харна уу.
18.	Элемент ба бэлгэдлийн тогтолцоо	Буддын шашны бэлгэдэл зүйг ашиглаж ирсэн. Авторын бэлгэдэл ба тэмдгийн тогтолцоо одоогоор илрээгүй.
Тусгай ба бусад хэв шинж		
19.	Атрибуцчлал	Өндөр гэгээний ажлыг судлаачид шууд хараад таньдаг ч атрибуцчлал хийхэд төвөгтэй байдаг. Формал стилистикийн хандлага хангалттай биш болохыг энэ шинж зааж байна. Тиймээс энэ бол бидний хараахан бүрэн “нээж чадаагүй тал” юм.
20.	Өрнө дорнын синтезчлэл	Занабазарын бүтээлүүдэд анализ хийхдээ бид өрнө, дорнын уламжлалуудыг харьцуулж синтез анализ хийх нь чухал. Учир нь түүний бүтээлүүд нь буддын урлагийн хувь хэмжээний онол, тигээс ангид ойлголт болжээ. Энэ нь түүний универсализмын шинж юм.

Зөвхөн дээрх судлаачид ч бус тухайлбал, урлаг судлаач Ц.Уранчимэг Өндөр гэгээний уран бүтээлийн хэв маягийн шинжлэлийг хийхдээ Н.Цүлтэмийн иконографийн арга зүйг үргэлжлүүлэн авч үзсэн байдаг. Тухайлбал, тэрээр “Монголын хүрээ хийдийн буддын шашны урлаг” бүтээлдээ “Өндөр гэгээн бурхдадаа үл анзаарагдам чимхлүүр хэсэг, зүүлт, хээ угалз зэргээр чимж бүтээдэг. Өндөр гэгээний олон бүтээлээс Язгуурын таван бурхдыг ард түмэн ороо бусгаа цагийн аюулаас хамгаалан авран үлджээ” (Уранчимэг 2016, 73) хэмээн бичсэн байдаг нь Н.Цүлтэмийн дүгнэлттэй нягт холбогдож байна. Түүнчлэн тэрээр соёлын агуулгыг онцлон бичжээ.

Г.Занабазарын хэв маягийг тодорхойлох структуралист загварчлал нь зөвхөн концепцийн хүрээнд хийгдсэн загварчлал юм. Тус ажил нь Өндөр гэгээн Занабазарын хэв маягийг нарийвчлан тодорхойлох, буддын урлагийн монгол хэв маягийг оновчтой тодорхойлоход ач холбогдолтой.

### Хэлэлцүүлэг

Дээрх Өндөр гэгээний ур хийц, монгол хэв шинжийн тухай судалгаанд хийсэн харьцуулсан дүн шинжилгээнээс гадна бусад арга зүйг ашиглан нарийвчлан тодорхойлох боломжтой.

Өрнөдийн урлаг судлалын зохиолд буддын урлагийн хэв маягийг ангилал зүйн хувьд Гандхар, Кашмир, Балба, Энэтхэг, Хятад-Төвөдийн хэмээн ангилдаг бол эртний төвөдийн зохиолчид энэтхэг, балба, монгол, хятад г.м ангилдаг байжээ. Харин “монгол загвар хийцийн тухай төвөд тэмдэглэл” (Сыртыпова 2019, 61-62) нь монгол урлагийн ангилал зүйн асуудалд чухал сурвалж болох боломжтой юм. Тус төвөд тэмдэглэлд дараах хоёр чухал зүйлийг тусгажээ. Нэгд, “доод монголын цутгуурын ур маягийг” Годан хаан (1206-1251) ба түүнээс дараа зургаан үеийн

хаадыг багтаасан түүхэн үед байсан тухай тэмдэглэл, мөн “дээд” монголын ур маяг, уйгур ур маяг ба хотан ур маяг гэж салаалдаг хэмээн ангилсан явдал юм (Сыртыпова 2019, 61-63).



*Зураг 1. Буддын урлахуйн “монгол хэв маяг”-ийг ангилсан төвөд ангилал<sup>4</sup>*

Дээрх эртний сударт бичигдсэн “монгол хэв маяг”-ийн ангилал нь өргөн хүрээнд түгэн дэлгэрээгүй нь өрнө дорнын ангилал зүйн ялгаатай байдал болон урлаг судлалын шинжлэх ухааны хүрээнд нарийвчилсан судалгаа хийгээгүйтэй холбоотой. Хэдий тийм боловч эртний судрын тус тэмдэглэл нь эх сурвалжийн арга зүйг ашиглан “монгол хэв маяг”-ийн нэршлийг тодорхойлохын сацуу, ялгамж шинжийг илрүүлэн тогтоох боломж байгааг харуулж байна. Урлаг судлал дахь Г.Занабазар судлалын онолын асуудлын цар хүрээг өргөжүүлэх шаардлага байгааг ч мөн илтгэж байна.

Мөн түүнчлэн, урлагийн хэв маягийг дорнын ангилал зүйн уламжлалт аргачлалаар Тан улсын үеийн эртний хятад хэв маяг, Эдогийн хэв маяг зэрэг ялангуяа хятад, японы урлагт ангилж ирсэн. Ийм жишиг тогтож тэдний тодорхойлсон хэв маяг, нэршлээр өрнө, дорнын урлаг судлалд өргөн ашиглагдаж байна. Тиймээс монголын судлаачид үүнийг жишиг болгож дорнын ангилал зүйн аргыг ашиглан монголын дүрслэх урлагийн хэв маяг, үечлэлийн асуудлыг илүү нарийвчлах, тэр хэрээр цараажуулах боломжтой гэж үзэж байна.

### Дүгнэлт

Судалгааны хүрээнд Занабазарын ур хийцийн онцлог хэв шинжүүдийг нэгтгэж, харьцуулсан шинжилгээ хийснээр зарим дүгнэлтэд хүрлээ.

1. Өндөр гэгээний хэв маягийг тодорхойлох ажлын үндсийг анх Н.Цүлтэм тавьжээ. Түүнийг залгамжилан Э.Ганевская, С.Д.Сыртыпова, Ц.Уранчимэг зэрэг эрдэмтэд өргөжүүлэн баяжуулжээ. Тэдний судалгаа их мастерын бүтээлдээ ашигласан эртнээс уламжлалтай хэв угалз, чимэглэл, соёлын агуулгын хүрээнд түлхүү хийгдэж хөгжиж ирсэн байна.
2. Дээр дурдсан судлаачдын дүн шинжилгээ, задлан шинжлэл нь формал, стилистикийн арга зүйг түлхүү ашигласан байна. Энэ нь хэв маягийн онолын үүднээс авч үзвэл, Г.Занабазар судлалд судалгааны олон чиглэл байгааг харуулж байна. Тиймээс урлаг судлалын өөр бусад арга, арга зүйг (тухайлбал, иконологи, иконографи, структуралист, герменевтик г.м) өргөн хүрээнд ашиглах нь нэн чухал байгааг харуулж байна. Цаашлаад салбар хоорондын судалгааг идэвхжүүлж түүхэн, философи гоо зүйн,

<sup>4</sup> Эх сурвалж: Сыртыпова, С.Д. 2019. *Өндөр гэгээн Занабазарын загвар хийц*. 61-62.

соёлын, нийгмийн болон бусад тусгай шинжид тулгуурлан үнэлэн дүгнэлт өгөх нь зүйтэй юм.

3. Өндөр гэгээний хэв маяг, түүний дэг сургуулийн хөгжлийн үечлэлийн тухай асуудлыг тусгайлан авч үзэх нь мөн чухал байгааг судалгаа харуулж байна. Тухайлбал, Занабазарын дэг сургуулийн *эхэн үе, оргил үе, сүүл үе* гэх мөчлөг бүхий гурамсан ангиллын загвар байх боломжтой.

Ийнхүү дээрх судалгааны ажил нь Өндөр гэгээн Занабазарын хэв маяг, буддын урлагийн монгол хэв маягийг оновчтой тодорхойлоход ач холбогдолтой төдийгүй түүнээс урган гарч ирж буй судалгааны өөр бусад хэрэгцээ шаардлагыг тодорхойлж байна.

### Ашигласан материалын жагсаалт

Бычков, В.В. 2002. *Эстетика*. Москва: Гардарики.

Вёльфлин, Г. 2004. *Ренессанс и барокко*. СПб.: Азбука-классика.

Ганевская, Э.В. 2004. “Скульптура Монголии XVII-XIX веков.” *Пять семей Будды. Металлическая скульптура северного буддизма IX--XIX вв. из собрания ГМВ: 78-81*. Москва.

Лосев, А.Ф. 1994. *Проблема художественного стиля*. Киев: Collegium.

Сыртыпова, С.Д. 2023. *Код Дзанабазара (1635–1723): монгольский стиль и кочевническая эстетика в буддийском искусстве Ваджраяны*. Москва: Наука-Восточная литература.

Сыртыпова, С.Д. 2019. *Өндөр гэгээн Занабазарын загвар хийц*. Улаанбаатар: Адмон.

Уранчимэг, Ц. 2016. *Монголын их хурээ хийдийн буддын шашны урлаг*. Улаанбаатар: ВСИ.

Цултэм, Н. 1984. *Искусство Монголии с древнейших времен до начала XX века*. Москва: Изобразительное искусство.

Elikhina, Yu. 2020. “The artistic Heritage of Dzanabadzar and his School preserved in the Collections of the State Hermitage.” *Ориенталистика*: 662-680.

Gombrich, Ernst. 1998. “Style.” *The art of art history: A critical Antology*: 150-163. Oxford.

Schapiro, Meyer. 1953. “Style.” *Antropology Today (The University of Chicago Press)*: 287-311.



**Зураг 1.** Аюуш. Занабазарын дэг сургуулийг дуурайсан хятад хийц<sup>5</sup>



**Зураг 2.** Амитаба. Занабазарын дэг сургуулийг дуурайсан хийц<sup>6</sup>

<sup>5</sup> Elikhina, Yu. 2020. "The artistic Heritage of Dzanabadzar and his School preserved in the Collections of the State Hermitage." *Ориенталистика*: 662-680.

<sup>6</sup> Elikhina, Yu. 2020. "The artistic Heritage of Dzanabadzar and his School preserved in the Collections of the State Hermitage." *Ориенталистика*: 662-680.